



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/857

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга баригдах болсонтой холбогдуулан Нийслэлийн ерөнхий боловсролын 42 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй, 87,874,449.25 (наян долоон сая найман зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун дөчин есөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад заасан барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 42 дугаар сургууль (Ц.Даваадоо)-д зөвшөөрсүгэй.

2. Акталж, данснаас хасагдаж байгаа барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой материалыг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
07 дугаар сарын 31-ны өдрийн
4834 дүгээр захирамжийн
хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2023.05.01/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	42 дугаар сургуулийн хичээлийн 1 дүгээр байрны барилга	1968	Сонгинохайрхан дүүрэг 2 дугаар хороо, Орбитын гудамж	81,742,458.03	19,300,302.81	62,442,155.22	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2020 оны 02-07-101/1066 дугаар дүгнэлт
2	Склад	2018	Сонгинохайрхан дүүрэг 2 дугаар хороо, Орбитын гудамж	6,131,991.22	635,633.40	5,496,357.82	
Нийт дүн				87,874,449.25	19,935,936.21	67,938,513.04	